



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 51

Номгон

**Аймгийн 2018 оны газар зохион байгуулалтын
нэмэлт төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2-ын “з” заалт, Газрын тухай хуулийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Дуудлага худалдааны анхны үнэ дээр дуудах 1 удаагийн интервалыг нэмж олгох газрыг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 34 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтын 5-д тусгагдсан аюулгүйн тойргийн баруун урд байршилтай төрийн байгууллагын зориулалттай 94м2 бүхий газрыг хассугай.

3. Нэмэлтээр батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөтэй хамтатган 2018 оны 12 дугаар сарын 31-ний дотор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын
02-ны өдрийн 51 дүгээр тогтоолын хавсралт

ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ ДЭЭРХ ДУУДАХ
1 УДААГИЙН ИНТЕРВАЛЫГ НЭМЖ ОЛГОХ ГАЗАР

№	Сумын нэр	Багийн нэр	Байршил	Талбайн солибоцол	Газрын хэмжээ /га/	Зориулалт	Техникийн нөхцөл	Хэрэгжүүлэх хугацаа				Хариуцах эзэн
								I	II	III	IV	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Баянхонгор	Номгон 1-р баг	Есөн Эрдэнэ захын баруун талд	X=632168.3954 Y=5116042.4020 X=632163.8210 Y=5116041.7410 X=632159.2897 Y=5116104.2925 X=632163.6727 Y=5116104.7404 X=632163.6762 Y=5116104.7207 X=632163.2902 Y=5116104.6646 X=632166.4680 Y=5116076.6071 X=632165.6788 Y=5116075.1603 X=632166.2624 Y=5116070.2627 X=632164.8233 Y=5116069.5682 X=632165.1661 Y=5116067.1391	0,0275	худалдаа үйлчилгээ	Дуудлага худалдаа	*	*			Г.Батжаргал Д.Алтангэрэл